



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/348

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх "Дундговь аймаг Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн барилгын сантехникийн засварын ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

|                           |               |                                        |
|---------------------------|---------------|----------------------------------------|
| Үнэлгээний хорооны дарга: | М.Цогзолмаа   | - АЗДТГазар ТЗУХ-ын дарга              |
| Гишүүд:                   | Т.Төрбат      | - Иргэний төлөөлөл                     |
|                           | Б.Батмөнх     | - Аймгийн Нисэх буудлын дарга          |
|                           | Т.Уранбайгаль | - АЗДТГ-ын ХЭЗХ-ийн<br>мэргэжилтэн     |
| Нарийн бичгийн дарга:     | Т.Асралт      | - ОНӨГ-ын ХАА<br>хариуцсан мэргэжилтэн |

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор хуралдуулж тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга /М.Цогзолмаа/-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Т.Асралт/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

480010104